

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**1. Төслийн товч танилцуулга**

1.2 Ордын уул техникийн нөхцөл

1.3 Хөрс хуулалт, элс олборлолтын ажлын техник технологийн сонголт

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга**3. Төсөлын гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт****4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ****5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

5.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга арга хэмжээний төлөвлөгөө.

5.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

5.3 Усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

5.4 Ан амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан төлөвлөгөө

5.5 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө****8. Нүүлгэх шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө****9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө****10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө****11. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө****12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр****13. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө****14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөлөлийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

1. Төслийн товч танилцуулга

Хүснэгт №1

№	Төслийн товч танилцуулга	
1	Төслийн нэр :	Алтны шороон орд
2	Төсөл хэрэгжүүлэгч:	"Жи Энд Юу Голд" ХХК
3	Төслийн дугаар :	2017/Т-046
4	Улсын бүртгэлийн дугаар :	9011156145
5	Регистрийн дугаар :	2675471
6	Хаяг, байршил :	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1-р 10 мянгат, 5-18
7	Утас :	
8	Төслийн байршил	
9	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш 900 км-т Гурванбулаг сумаас зүүн урд тийш 25 км-т, байр зүйн зургийн L-47-30 хавтгайнуудад байрладаг	
10	X:84982.34	Y:234378.04
11	X:85550.23	Y:234376
12	X:84945.63	Y:234472.97
13	X:85556.73	Y:235738.40

Төслийн товч тодорхойлолт:

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт орших “Ихрийн ам” нэртэй тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2006 оны 09 дугаар сарын 12-ны өдөр АМГ-ын ГУУКА-ны даргын шийдвэрээр MV-021800А тоот 77.09 га талбай бүхий Ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Жи энд Юу голд” ХХК-д 30 жилийн хугацаагаар олгожээ.

Ихрийн ам нэртэй алтны шороон ордод 2002 онд нарийвчилсан хайгуул хийж, гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд ЭБЭХЯ, ЭБМЗ-н 2002 оны 02-р сарын 04-ны (дүгнэлтийн дугаар 07) хурлаар хэлэлцэн нөөцийг баталсан.

АМХЭГ-ын даргын тушаалаар MV-021800А тусгай зөвшөөрлийн талбайн 77.09 га талбайд химийн цэврээр 653,71 кг алтны нөөц бүртгэгдсэн байна. Үүнээс урд онуудад олборлосон металл 218,4 кг, үлдэгдэл нөөц 435,3 кг-аас 3С,4С блокуудыг олборлож 73.94 кг металл олборлохоор 2023 оны төлөвлөгөөг боловсруулав.

1.1 Ордын уул техникийн нөхцөл

Тухайн орд нь дунд гүний, мөнхийн цэвдэгтэй, олборлоход хүнд, дунд зэргийн агуулгатайгаас гадна хот болон аймгийн төвөөс алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн бүс нутагт оршино.

Ордын дундаж агуулга талбайн нийт тархалтаараа жигдэвтэр, харин ордын баруун хэсэгтээ босоо тархалтаараа доошлох тусам ихсэж байгаа нь тогтоогдсон байна. Ордын талбайн газрын гадаргаас доош 3.0 м-ээс эхлэн олон жилийн цэвдэгтэй. Ордын нөөцийн тооцооны хил заагаас баруун тийш хуулсан хөрсийг овоолох, зөөж тээвэрлэхэд лицензийн талбай хангалттай юм.

Хөрсийг хуулж дууссаны дараа ашигт давхаргыг шууд олборлох боломжгүй юм. Учир нь алт агуулсан элс нь мөн адил хэмжээний цэвдэгтэй тул шууд угааж олборлоход металлын хаягдал ихэснэ. Иймд элсийг овоолго хийж, гэссэний дараа угааж олборлох нь ашигтай.

Ашигт давхарга нь 6.3-20м гүнд олон жилийн цэвдэгт байрладаг 15-25%-н шаварлаг хольцоор сулавтар барьцалдсан 40-50%-н хайргархаг хольц агуулсан элсэнцэр, хайрга, дайрга, ул чулуулгийн өгөршлийн хэмхдэс бүхий III-V-р зэргийн хатуулагтай сэвсгэр хурдсаас тогтоно. Хуулах хөрсний 1/3 хувийг ус эзэлдэг тул олборлолтын явцад ус зайлуулах, шүүх асар их ажил хийгддэг. Үүнээс шалтгаалсан уулын ажлын хүндрэл ихтэй. Ашигт давхарга нь гүн ухагдсан цүнхээл, үүр маягаар тогтоогүй нь ул хөрсний цэвэрлэгээ хийхэд хүндрэлгүй.

Олон жилийн цэвдэгтэй шороон ордыг ашиглах онцлог тал нь тухайн орд хөлдүү төлөвт оршдогоос гадна үйлдвэр байрласан газар нутгийн цаг уурын хүндрэлтэй нөхцөл болон ордын байрших онцлогоос шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл ашиглалтын маш эрчимтэй явуулах, улирлын чанартай ажлыг зохион байгуулах ил уурхайн техникт тавигдах онцгой шаардлага гарч ирдэг. Учир нь цэвдэгтэй орд нь техникийн элэгдэл хорогдлыг үлэмж хэмжээгээр ихэсгэдэг.

Энэ орд нь усны хүндрэлтэй боловч дээрхи усны асуудлыг ашиглалтын зөв технологи хэрэглэснээр олборлолт явуулж буй хэсэгт усны хүндрэл үүсгэхгүйгээр карьерын дотор болон гадна хуримтлуулснаар элс угаах технологийн усны хэрэглээг хангах боломж олгож буй давуу талтай юм.

Улирлын чанартай ажилд баяжуулах хэсэг буюу элс угаалтын ажил хамаарах бөгөөд энэ нь цаг уурын нөхцөлөөс шалтгаалахаас гадна цэвдэгтэй хөлдүү элсийг баяжуулахаас өмнө зайлшгүй гэсгээх шаардлага гардагтай холбоотой юм. Иймд улирлын чанартай ажлыг зохион байгуулах ажил энд чухал юм.

1.2 Хөрс хуулалт, элс олборлолтын ажлын техник технологийн сонголт

Ордыг ил уурхайн аргаар ашигласан ба уурхайн хөрс хуулалтын ажлыг экскавацлалт дотоод овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэсэн. Хөрс хуулалтын ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, дотоод овоолго хийх орон зай бий болох хүртэл гадаад овоолго хийж энэхүү орон зай бий болсон үед ордын үйл ажиллагаа зогсолт дотоод овоолго хийнэ.

Элс олборлолтын ажлыг өрөмдлөг-тэсэлгээ-экскавацлалт-авто тээвэр-агуулах гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэсэн. Элс олборлолтын ажлыг экскаватор болон автосамосвалын тусламжтайгаар тусламжтай угаах тоног төхөөрөмжийн ойролцоо овоолго хийсэн.

Уулын ажлын үндсэн техникт коматцу D-375A,D-155A, зэрэг бульдозер-ууд, коматцу PC-600, CAT-349 экскаваторуудыг уул техникийн тухайн нөхцөлд газар дээр нь тааруулан сонгож ажиллуулсан. Тусгайлан зассан талбайд хөрс элсийг бульдозероор овоолж, экскаватороор хөрсийг талбайгаас гаргах, элсийг угаах төхөөрөмжинд өгөх ажлыг мөн хослуулан хийсэн аль ашигтай, хаягдал багатай баяжуулалтын системийг сонгож ажилласан. Угаах төхөөрөмжийн элс хүлээн авах бункерийг элсээр хангах ажлыг ойрын зайд бага оврын коматцу Д-65Е-12 бульдозероор түрж, шаардлагатай тохиолдолд экскаватор, ачигч машин ашиглан ажиллана.

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин , нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Ихрийн уурхай нь Улаанбаатар хотоос 880 км зайд Баянхонгор аймгаас 260 км зайд Гурванбулаг сумаас 20,0 км-т оршдог ба газарзүйн хувьд мөнхийн цэвдэгтэй бүс нутаг юм . Ил уурхайн ашиглалтын системийн хувьд гадаад овоолго хийх нь зайлшгүй ба эдгээр отволууд нь олон жилийн цэвдэг учраас тухайн үеийн уулын ажил явуулж байсан цаг хугацаанаас /6-8 сар/ хамаарч цэвдгийн хайлалт их байсны улмаас цэвдгийг нэг газраа өндөр отволдох боломжгүй гадаад овоолго нь обьём бага талбай их хэмжээгээр хамаарч нөхөн сэргээлт хийхэд хүндрэл учруулах нь зайлшгүй нэг хүчин зүйл болж байсан. Энэхүү цэвдгийн тархсан отволууд нь түрэх, ухаж ачих, нөхөн сэргээх явцыг удаашруулж байсан. Мөн Ихрийн уурхай нь мөнхийн цэвдэгтэй учир хөрсийг сийрэгжүүлэх тэсэлгээний ажил тогтмол хийгддэг ба тэсэлгээний үеэр мал, хүн амьтанд аюул учирч болзошгүй учир харуул хамгаалалт дотоод хяналтыг дээд зэргээр хангаж тэсэлгээ хийгдэх бүрт 4 зүгт харуул гаргаж огт эрсдэл гэмтэлгүй ажиллана.

3. Төсөлын гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт

Уурхайн олборлолтын ажил явуулах үед газар орчны эвдрэл тодорхой хэмжээгээр гарсан. Уулын ажил явуулах талбайд тоног төхөөрөмж байрлуулж, суурилуулж байгууламжуудын байршлыг өөрчлөгдөхөөргүй, байнгын байрлах газар оновчтой байршуулж үйлдвэр зохион байгуулалтын ажлыг зохих журмын дагуу явуулна.

Ордод олборлолтын ажил явуулснаар орд орчмын унаган төрх бага зэргийн алдагдахаас өөр орон нутагт үзүүлэх сөрөг нөлөө бага боловч доорхи арга хэмжээнүүдийг тус компани 2023 оны үйлдвэрлэлийн явцад авч хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Уулын ажлыг газар эдэлбэрийн хуулийн дагуу аймаг, сум, багийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн зураг төсөлд тусгагдсан хил хязгаарын дотор явуулна.

- Хуулсан хөрсийг аль болох дотоод овоолгод хийхээр тооцож уулын ажлыг хийнэ. Угаах төхөөрөмжөөс гарч байгаа үйлдвэрийн хаягдал усыг эргүүлэн ашиглаж, эргэлтийн усан санг байгуулж ажиллана.

- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэд зориулагдсан замыг зөвхөн нэг маршрутаар хийсэн ба зөвхөн хийсэн замаараа олборлолтоо явуулна.

- Уурхайд ажилласан машин, техникүүдийг шатахуунаар цэнэглэх, засвар хийх цэгтэй болсон зөвхөн тухайн цэгт шатхуун түгээж засвар хийж хэвшүүлнэ.

- Ургамлын хар шороон хөрсийг тогтоогдсон хэмжээний зузаантайгаар олборлолт явагдах талбайгаас хуулан авч, тусгай овоолгод байрлуулна.

- Хөрсийг гадаад овоолгоос болон уулын ажлын ахилтын үеийн хөрсийг ашиглагдсан хоосон орон зайд бульдозероор түрж, машинаар зөөвөрлөн авчирч тараан тэгшилнэ.

4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа нөлөөллийг бууруулах улмаар арилгах нь компанийн гол үүрэг бөгөөд 2023 онд байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэлд “Жи Энд Юу Голд” ХХК-аас орд газрын байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, орчны хяналт явуулахад шаардагдах зардлыг Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа түлш, шатахуун, материалын үнэ, ажил үйлчилгээний хөлсний тариф ба жишиг үнийг баримжаалан шинэчлэн тооцоолсон болно.

5. Сөрөг нөлөөллийг буулгах арга хэмжээний төлөвлөгөө

5.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга арга хэмжээний төлөвлөгөө.

Агаарын бохирдлыг үүсгэгч гол хүчин зүйлсэд тээврийн хэрэгсэл ба техникийн угарын хий, түүнчлэн хөрс хуулалтын үед болон тээвэрлэлтийн явцад үүсэх тоос зэрэг болно. Тиймээс агаарт зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү бохирдолтыг үүсгэхээс сэргийлэх үүднээс уулын ажилд ажиллаж байгаа техник хэрэгслийн байдалд хяналт тавьж цаг хугацаанд нь үйлчилгээ, засвар хийх мөн тоосжилтыг багасгах үүднээс замын усалгааг тогтмол хийж ажиллана. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаарын бохирдлын төвшинг тусгайлсан лаборатори-д дүн шинжилгээ хийлгэж хянаж ажиллана. /Хүснэгт №2/

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлөл	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн гадаад замуудад хайрга чулуу дэвсэх замыг тухай бүрд усалж байх	Тоосжилтын үед харагдах орчин хязгаалагдахаас гадна уурхайн бүсийн ан амьтан ургамалд сөрөг нөлөөтэй	ш	100	24	2400	2021 онд 4 сар ажиллана тоосжилтоос хамаарч 7 хоногт 2-3 удаа	Үйлдвэрлэлийн зардалд орно
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Гүний ус ашигладаггүй бөгөөд үйлдвэрлэлийн усан санг гадаргын уснаас зөөврөөр үүсгэсэн	байхгүй	ш	-	-	-	-	Урьд онуудад хуримтлагдсан усны нөөцтэй
3	Хөрсөн бүрхэвч	шимт хөрсний овоолго хийж хадгалах, олон салаа зам гаргахгүй байх	уурхайн орчны замыг стандартын дагуу тавих тэмдэгжүүлэх ажил хийх олон салаа зам гарах нь хөрсөнд эвдрэлд оруулна	ш	300	2	300	шимт хөрсний овоолгыг 2 жилээс дээш хугацаанд хадгалах ургамалжуулах	Үйлдвэрлэлийн зардалд орно
4	Газрын хэвлий	2023 онд 1 га-д техникийн нөхөн сэргээлт хийнэ.	-	-	-	-	-	-	-
5	Ургамалын нөмрөг	-	-	-	-	-	-	-	-
6	Амьтны аймаг	Хаягдлын аж ахуйн хогийн цэгийг мал ан амьтан орохооргүй хаалт хашаа хийж сайжруулах сэргээн засварлах ажлууд хийгдэнэ	-	-	-	-	-	-	-
	нийт						2700		

5.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүнээр хөрсийг бохирдуулахгүй байх, сэргийлэх үүднээс ШТМ-ын агуулахад онцгой байдал ба асгарахаас урьдчилан арга хэмжээ авах зорилгоор тусгайлан тооцоолсон талбайд засах мөн авто тээврийн хэрэгслийн болон техникийн үзлэг ба засвар хийх байнгын зогсоол механик цехийг бий болгосон тухай засварын талбайгаас өөр газарт засвар үйлчилгээ хийхгүй хэвшүүлэн ажиллана. Ордыг ашиглаж эхлэхээс өмнө ургамлын үржил шимт хөрсийг хуулж маркшейдерийн зураглалын дагуу ашиглалтын хүрээнээс 10-15 метрийн зайд түрж ковшоор хэлбэршүүлнэ. Илүүдэл шаардлагагүй зам үүсэхээс сэргийлж замын тэмдэг тэмдэглэгээгээ сайжруулах ажлыг хийнэ. Мөн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний бохирдлын түвшинг лабораторид дүн шинжилгээнд хамруулна.

Олон салаа зам үүсэхээс сэргийлэж уурхайн замыг тэмдэгжүүлсэн байдал төлөвлөгөөр сэргээн засварлаж шаардлагатай газар тэмдэг тэмдэглэгээ шинээр хийнэ.

Зураг-1



Машин механизмын засвар үйлчилгээний талбай тухай онд сайжруулах ажил төлөвлөсөн

Зураг 3



5.3 Усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах үүднээс элс угаалтыг уурхайн мөнхийн цэвдгийн гэсэлт, карьерийн хананаас шүүрэх уснаас болон бороо, цас, үерийн усыг хуримтлуулан эргэлтийн системд оруулан ашигласан, эргэлтийн ус нь голын урсац руу орж бохирдуулахгүйгээр хийгдсэн. Тиймээс үйлдвэрлэлд ашиглах усыг цэвэршүүлэх зориулалттай тунгаах нуур хийн лаг шаврыг нь тунгаан цааш нь хайрган далан хийн цэвэршүүлж цэвэр усны нуур луу нийлүүлэн тэндээсээ дахин эргэлтэд оруулан ашиглана. Энэ нь усыг хэмнэх чухал ач холбогдолтой. Мөн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу гадаргын болон гүний усны түвшинг лаборатори-д дүн шинжилгээнд хамруулж ажиллана.

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ихрийн уурхайн ашиглалтын систем нь “Ил аргаар дотоод болон гадаад овоолготой ашиглалтын систем” хэрэглэхээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уулын ажилыг явуулна. Энэ нь уурхайн үйл ажиллагаа эхлэх үед хоосон орон зай үүсгэх зорилгоор гадаад овоолго хийж цаашид ашигласан орон зайд ахилтын хөрсөөр дотоод овоолго хийх байдлаар уулын ажил ахидаг сайн талтай ашиглалтын систем юм. Гэвч гэсэлтийн үед цэвдэгтэй хөрс нь гэсэлт хайлалт ихтэй учир отвалдахад хүндрэл ихтэй бага өндөртэйгээр том талбай хамран байршдаг муу талтай. (Нөхөн сэргээлтийн хэмжээг хүснэгт 3-т харуулав).

Хүснэгт №3

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө		Тайлбар
		Га	Мян.м ³	
1	Хэмжих нэгж	Га	Мян.м ³	
2	Уурхайн эдэлбэр	77,09		
3	Уулын ажилд хамрагдах талбай	2	306.8	
Ү Ү Н Э Э С	а/. 2023 оны нөхөн сэргээлт хийх	4	312.8	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу 4.0 га газарт техникийн нөхөн сэргээлт хийнэ.
	б/. Дотоод овоолгоор	1	153.4	Уурхайн олборлолтын явцад 1.0 га-д дотоод овоолго хийнэ.
	в/ Гадаад овоолгоор	1	153.4	Уулын ажил ахих үед ахилтын хөрсөөр техникийн нөхөн сэргээлт уулын ажил цуг хийнэ.
	г/. Шимт хөрсний нөхөн сэргээлт	1	3.0	шимт хөрсөөр 1.0 га талбайд хучилт хийнэ.
	д/ Биологийн нөхөн сэргээлт	1	3.0	2023 онд биологийн нөхөн сэргээлт 1.0 га талбайд хийхээр төлөвлөв.

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдалын үнэлгээний тухай хуулийн 3,1,11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унган төрх, хэв шинж амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын хүснэгтээр үзүүлэв.

Баянхонгор аймгийн БОГазрын саналыг 2023 оны менежментийн төлөвлөгөөнд тусгав.

1. Аймгийн БОГазрын саналын дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Ихрийн амны дээд хэсэгт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эвдрэлд оруулж, орхигдсон 10 га табайд техникийн нөхөн сэргээлт хүлээлгэж өгнө (Тус талбайд 2022 онд техникийн нөхөн сэргээлт 10 га талбайд хийгдсэн байгааг 2023 онд 2,5 сая.төг-р хэлбэржүүлэлтийн ажил нэмж хийж хүлээлгэж өгнө).

2. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус онд 1000-аас доошгүй мод тухайн бус нутагт дасан зохицох чадвартай модыг тарьж, хайс хамгаалалтын асуудлыг шийдвэрлэнэ.

3. Байгаль орчны аудит хийлгэнэ /2023 онд/

8. Нүүлгэх шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй тул. Нүүлгэх шилжүүлэх төлөвлөгөөний гэрээ төлөвлөгөө тусгаагүй байгаа боловч нүүлгэн шүлжүүлэх нөхөн олговор олгох айл өрх айлын өвөлжөө хаваржаа гарч ирвэл тухайн үед нь гэрээ хийж хамтар ч ажиллана. /Хүснэгт №6/

Хүснэгт №4

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	байхгүй	-	-	-	-	-	-	БОНБҮ-ийн тухай хууль

9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс, археологи, палентологийн холбоотой үнэт олдвор одоогоор илрээгүй байна. Хэрвээ уурхайн олборлолтын үед түүх соёлын үнэт зүйлс олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17,11-ийн дагуу түүнийг хөндөж эвдэхгүйгээр хамгаалж мэрэгжлийн болон холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж ажиллахаар төлөвлөсөн. /Хүснэгт №5/

№	Нөлөөл өлд өртөх иргэд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Археологийн дурсгал	-	-	-	-	-	-	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17,11-ийн дагуу
2	Палеонтологийн дурсгал	-	-	-	-	-	-	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17,11-ийн дагуу
	Нийт							

10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №6

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, /Мян.төг/	Тоо хэмжээ	нийт зардал /Мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Болзошгүй осол саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, хянах. Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвшүүлэх	Үйл ажиллагааны турш	200	1	200	Сургалтыг уурхай дээр сард 1 удаа зохион байгуулах	Гамшигаас хамгаалах хууль, 27.1 Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, Тэсэлгээний аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөнө

11. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт
№7

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Үйлдвэрийн	Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутагтай хийсэн гэрээний дагуу сумын хогын цэгт байршуулна	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжид	ш	150	1	150	Гурван булаг сумын удирдалгаас зааж өгсөн хогийн цэгт булшилах	Тэсэлгээний аюулгүй ажиллаганы дүрмийг дагаж мөрдөнө
2	Ахуйн	хог хаягдалыг тогтмол зайлуулаагүй гээс орчин бохирдох	Уурхайн хог хаягдалын цэг орчимд	ш	200	1	200	Сумын хогийн цэгт байршуулах	Хог хаягдлыг тухай хууль
3	Аюултай	-	-	-	-	-	-	-	-
3	Нийт						350		

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт №8

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтийн цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	нийт зардал мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачилал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын чанар	Ажилчидын байр Авто зогсоол	6 сард 1 удаа	1	400	400		MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Усны хяналт шинжилгээ	Унд ахуйг хангаж буй усны эх үүсвэрээс	6 сард 1 удаа	1	400	400		MNS (ISO) 4867:1999 Усны яанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
3	Хөрсний төлөв байдал, бохирдол	Ажилчидын байр Карьераас	6 сард 1 удаа	1	400	400		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
	Нийт			3		1200		

**13. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион
байгуулалтын төлөвлөгөө**

Хүснэгт №9

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2020 он				
			9сар	10сар	11сар		
1	2	3	4	5	6	7	
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчны хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалт зохион байгуулах	100	1	2	2	ХАБЭА инженер ХАБЭА ажилтан	Хөдөлмөр хамагаалал аюулгүй ажилгааны дүрэм, Галын аюулгүй ажилгааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо
2	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах. Холбогдох дүүргийн байгаль орчны алба. Байгаль орчны хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	100	1	1	1	БОХ нэгжийн ажилтан	Хөдөлмөр хамагаалал аюулгүй ажилгааны дүрэм, Галын аюулгүй ажилгааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо
3	Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах, үйлчлүүлэх талаар тохиролцох, үйлдвэрлэлийн онцлогтой холбогдсон гарч болзошгүй өвчлөл, гэмтэл, хордлогын талаар мэдээлэл харилцан	Дотоод зардалаар	2	2	2	ХАБЭА инженер ХАБЭА ажилтан	Хөдөлмөр хамагаалал аюулгүй ажилгааны дүрэм, Галын аюулгүй ажилгааны дүрэм ISO 14001:2004 Байгаль

	солилцож зохих бэлтгэлийг хангах						Орчны Удирдлагын Тогтолцоо
	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	500	2	2	2	ХАБЭА инженер ХАБЭА ажилтан	Хөдөлмөр хамаагалал аюулгүй ажилгааны дүрэм, Галын аюулгүй ажилгааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо
	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10-1 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгуулгаар хийлгэх	гэрээний үндсэн дээр	3 жилд 1 удаа			БОХ нэгжийн ажилтан	Хөдөлмөр хамаагалал аюулгүй ажилгааны дүрэм, Галын аюулгүй ажилгааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо
	Нийт	700					

**14.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг
нөлөөлөлийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

Хүснэгт №10

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээлэлийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцсан албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ИТХ	Уулзалт	төслийг танилцуулах санал авч дэмжүүлэх	2023 оны 8-р сарын 14	200	БОХ нэгжийн ажилтан	Гурванбулаг сумын ИТХ
2	БОАЖЯ-ын ХБОБНГ-т	Менежментийн тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2023 оны 8-р сарын 14	50	БОХ нэгжийн ажилтан	БОАЖЯ-ын ХБОБНГ-т
3					250		

15. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нөхөн сэргээлтийн зардал (Бусад зардал нь үйлдвэрлэлийн зардалд орсон)

Хүснэгт №11

№	Үзүүлэлт	Талбай /га/	Зардал /мян.төг/	Тайлбар
1	Шимт хөрсөөр хучих	1	1500	Өмнөх онуудад хийсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн 1 га талбайг шимт хөрсөөр хучна.
			1000	Уурхайн ойролцоох малчин айлуудын өвөлжөөнөөс бууц зөөж шимт хөрстэйгөө холж тараана.
2	Биологийн нөхөн сэргээлт	1	1750	биологийн олон наст ургамлын үр авна
			750	Шимт хөрсөөр хучсан 1 га талбайдаа биологийн олон наст ургамал тарина.
3	Дүйцүүлэн хамгаалах	10	2500	Ихрийн амны дээд хэсэгт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эвдрэлд оруулж орхисон 10 га талбайд 2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Уг талбайг хэлбэржүүлэн 2023 онд орон нутагт хүлээлгэн өгнө.
4	Нийт	12	7500	

Мэдээлэлийн үнэн зөвийг баталсан:

БОХ нэгжийн ажилтан

/ Д.Батхуяг /

2023 оны 6 дүгээр сар 28 өдөр



УУЛ УУРХАЙН ӨЛБӨРЛӨЛТЭЙН
“ЖИ ЭНДИОУ ГОЛД”
ХЯНГААРЛАГДМАЛ ХАРНУЦЛАГАТАЙ
КОМПАНИ

Улаанбаатар 210524, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Нх сургуулийн сулааж, 52-р оффис
Утас: Факс: 7017-4070

2023-06-08

023/034

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ХБӨБЗГ-ЫН ДАРГА Б.БУЯННЭМЭХ
ТАНАА

Хүсэлт гаргах нь

Манай компани Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын 2-р багийн нутагт МУ-021800 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд алтны шороон ордын уурхайн үйл ажиллагааг 2021 оноос явуулж байна.

2023 оны үйл ажиллагаа эхлэхтэй холбоотойгоор холбогдох бичиг баримтуудыг төрийн захиргааны байгууллагуудаас бүрдүүлэн ажиллаж байна. Уурхайн байгаль орчны аудитын тайланг энэ онд хийлгэхээр төлөвлөж байгаа бөгөөд уурхайн үйл ажиллагаа эхлэхэд зайлшгүй шаардлагатай болох 2023 оны межаментгийн төлөвлөгөөг батлаж өгч манай компаний ажилд тусална уу.

Жич: Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгэх ажлын гэрээг хавсаргаа.

ХҮНДЭТГЭСЭН
ЗАХИРАЛ



Г.ЧИНГЭЛ

ЭКОЛОГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 06 сарын 01 өдөр

Дугаар A/25

Улаанбаатар хот

Нэг талаас “Жи энд Юу голд” ХХК /цаашид “Захиалагч тал” гэх/, нөгөө талаас байгаль орчны аудит хийх эрх бүхий “ЭБГ КОНСАЛТИНГ” ХХК /цаашид “Гүйцэтгэгч тал” гэх/ нар экологийн хариуцлагын гэрээг /цаашид “Энэхүү гэрээ” гэх/-г харилцан тохиролцов.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний дагуу “Жи энд Юу голд” ХХК-ийн захиалгаар түүний “Ихэрийн-Ам” нэртэй ашигт малтмалын ашиглалтын **MV-21800** тоот тусгай зөвшөөрөл бүхий **Алтны шороон ордыг** ил аргаар ашиглах уурхайн төслийн үйл ажиллагаанд Гүйцэтгэгч талын хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг зөвшилцөн санал нийлж экологийн хариуцлага хүлээхээр харилцан тохиролцов.

1.2 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Иргэний Хуулийн 189.5 дахь хэсэг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 12 дүгээр сарын 25-ний өдрийн А-809 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”-ыг удирдлага болгосон бөгөөд гэрээний зорилго нь талуудын хооронд үүсэх экологийн хариуцлага хүлээхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.3 Байгаль орчны аудитын зорилго нь Захиалагч талыг буруутгах, ямар нэгэн хуулийн хариуцлага хүлээлгэх зэрэг үзэл санааг агуулаагүй бөгөөд байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болох сөрөг нөлөөллөөс сэргийлэх, “Жи энд Юу голд” ХХК-ийн Алтны шороон ордыг ашиглах уурхайн үйл ажиллагаанд шууд хамааралтай байгаль орчны хууль, тогтоомжийн заалт бүрийн хэрэгжилтэд ил тод, шударга, байгаа бодит баримтад тулгуурласан үнэлгээ хийж, нөхөрсөг зөвлөлгөө өгч, зөвхөн төслийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх, байгаль орчинд эрсдэл учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл гаргахгүй байхад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлж гуравдагч этгээдэд үл хамааралтай зөвхөн хоёр талын харилцан итгэлцэлд үндэслэнэ.

Хоёр. Ерөнхий нөхцөл

2.1 Захиалагч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу аудит хийлгэж, Байгаль орчны тухай хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлдөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийн байдлад хийсэн байгаль орчны аудитын үнэлэмжээр тодорхойлсон байгаль орчинд ээлтэй сайн технологи, туршлага, ололтыг улам баталгаажуулах, дутагдал, доголдолтой зүйлсийг зөвлөмжид заасан хугацаанд засаж сайжруулах үүрэг хариуцлага хүлээнэ.

2.2 Гүйцэтгэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчны аудитыг гүйцэтгэж, байгаль орчны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, байгаль орчны үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, стандартын хэрэгжилтийг нотлох баримтад тулгуурлан үндэслэлтэй дүгнэлт, зөвлөмж боловсруулах үүрэг хариуцлага хүлээнэ.

2.3 Талууд нь байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах, төслийн экологи, эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх, учирч болзошгүй хохирол, эрсдэл, алдагдалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үнэн зөв тодорхойлон харилцан итгэлцэлийн үндсэн дээр хамтран ажиллана.

2.4 Захиалагч тал үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцийн тухай, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах дүрэм, журам, ашигт малтмал ашиглах зөвшөөрөл, БОННҮнэлгээний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнүүд, тэдгээрийн хэрэгжилт, төрийн захиргааны төв болон орон нутгийн



байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг даалгавар, зөвлөмж, дүгнэлтээр өгөгдсөн ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан зэрэг баримт бичиг, Гүйцэтгэгч тал аудит хийхтэй холбогдсон бодлого, эрхзүй, аудит хийх эрхийн зөвшөөрөл, аудиторчуудын мэргэжлийн гэрчилгээ, аудитын аргачлал, нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын шалгуур асуулга бүхий үнэлэмжийн хуудсын жагсаалт зэрэг баримт бичгийн мэдээллийг харилцан нээлттэй солилцож аудитын үнэлэмжийг үндэслэлтэй хийх бэлтгэлийг хамтран урьдчилан бүрдүүлнэ.

2.5 Байгаль орчны аудитын ажлын хөтөлбөр, түүнийг хамтран хэрэгжүүлэх боломжийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.

Гурав. Захиалагчийн үүрэг хариуцлага

3.1 Байгаль орчны аудит хийхэд шаардагдах байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан, газрын хянан баталгааны тайлан, дотоод аудитын тайлан, байгалийн нөөц ашигласан, ус, агаар бохирдуулсан болон байгаль орчны бусад зөвшөөрлийн төлбөрийн баримтууд, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, илтгэх хуудас, дотоод аудитын тайлан болон байгаль орчны бусад баримт бичгүүдийг аудитын хугацаанд ажил гүйцэтгэгчийн мэдэлд саадгүй түр шилжүүлнэ.

3.2 Гүйцэтгэгчийн баталсан аудитын ажлын хөтөлбөрийн дагуу баримт бичиг урьдчилан судалж мэдээлэл бүрдүүлэх, газар дээр нь очиж ажиллаж, төслийн үйл ажиллагаатай бүрэн танилцах боломжийг олгоно.

3.3 Гүйцэтгэгчийн боловсруулсан аудитын ажлын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явц /аудитын бэлтгэл, аудитын нээлт, аудитын газар дээр ажиллах, аудитын хаалт/, тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэлэлцэх, батлах бүх үе шатанд хамтран ажиллаж, аудитын үнэлэмж, дүгнэлт, зөвлөмжийн үнэн зөв, хэрэгжих технологи, санхүүгийн үндэслэлтэй байдалд оролцож санал зөвлөмжөө тусган тайлангийн эцсийн хувилбарыг зөвшилцөн тохиролцоно. Санал нийлээгүй зүйл гарвал тайланд Захиалагч, гүйцэтгэлийн байр суурийг тодорхой бичиж үлдээнэ.

3.4 Захиалагч нь байгаль орчны аудитын дүгнэлт, зөвлөмжид тусгасан үйл ажиллагааг хугацаанд нь хэрэгжүүлж гүйцэтгэлийн тайланг аймгийн байгаль хамгаалах газарт зөвлөмжид заасан хугацаанд хүргүүлнэ.

3.5 Захиалагч нь зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлаа хуулийн дагуу эрх бүхий байгууллагад тайлагнана.

Дөрөв. Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага

4.1 Гүйцэтгэгч нь байгаль орчны аудит хийлгэхээр захиалагчаас ирүүлсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан, газрын хянан баталгааны тайлан, дотоод аудитын тайлан, байгалийн нөөц ашигласан, ус, агаар бохирдуулсан болон байгаль орчны бусад зөвшөөрлийн төлбөрийн баримтууд, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, илтгэх хуудас, байгаль орчны бусад баримт бичгүүдийг бүрэн бүтэн байдлыг хариуцах ба жагсаалтаар хүлээн авч, ажил дууссаны дараагаар хүлээлгэн өгнө.

4.2 Гүйцэтгэгч нь Байгаль орчны аудит гүйцэтгэхээр 2023 оны 06 сарын 01-ны өдрийн хамтран баталсан ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд "Жи энд Юу голд" ХХК-ний алтны шороон ордыг ил аргаар ашиглах **MV-21800** тоот тусгай зөвшөөрөл бүхий төслийн үйл ажиллагаанд аудитыг мэргэжлийн ур чадварын өндөр түвшинд аудитын зарчим, аргачлалын хүрээнд урьдчилан судалж тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр харьцуулалт хийж, нотлох баримт бүрдүүлэн, түүнд тулгуурлан тайланг боловсруулж дуусган Захиалагчид хүлээлгэн өгнө.

4.3 Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжид "Ихэрийн-Ам"-ны Алтны шороон ордыг ашиглах" төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй



аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, төслийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн акт, стандартын хэм хэмжээ зэрэг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг үндэслэлтэй тооцож тусгана.

4.4 Гүйцэтгэгч нь байгаль орчны аудитаар гарсан дүгнэлт, зөвлөмжийн үнэн зөв байдлыг хариуцна.

4.5 Гүйцэтгэгч нь Захиалагч талаас хүлээн авсан баримт бичиг, гэрээний дагуу гаргасан аудитын дүгнэлт болон түүнд агуулагдаж байгаа аливаа мэдээлэл, тайланг боловсруулахад үндэслэл болгосон баримт, мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх, гуравдагч этгээд олж мэдэх боломжийг бүрдүүлэхгүй байх, эрх бүхий байгууллагад гаргаж өгөхгүй байх үүрэгтэй.

4.6 Гүйцэтгэгч нь талуудын хооронд байгуулагдсан ажил гүйцэтгэх гэрээ болон энэхүү гэрээний дагуу олж мэдсэн аливаа мэдээлэл, байгаль орчны аудитын тайлан, зөвлөмжийг аливаа бусад хэлбэрээр ашиглах, хууль хяналтын байгууллагад нотлох баримтаар гаргах болон олон нийтэд зарлан мэдээлэхийг хатуу хориглоно.

4.7 Гүйцэтгэгч тал нь энэхүү гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагчид учирсан хохирол, зардлыг нөхөн төлөх үүрэгтэй

Тав. Хамтран хүлээх үүрэг

5.1 Энэхүү гэрээг хоёр тал адил хүчинтэй 2 хувь үйлдэж, гэрээний хугацаа дуустал талууд хадгална.

5.2 Байгаль орчны аудитын тайланг гүйцэтгэгч 2 хувь үйлдэж, холбогдох хавсралтын хамт зөвхөн Захиалагчид хүлээлгэн өгнө.

Зургаа. Мэдээллийн нууцыг хадгалах

6.1 "Гүйцэтгэгч" нь "Захиалагч"-аас хүлээн авсан бүх мэдээлэл, ялангуяа нууцад тооцогдох мэдээллийг төр, төрийн бус байгууллага, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст зарлан тараахгүй бөгөөд энэ гэрээнд дурьдсан зорилтоос өөрөөр хувьдаа ашиг олохын тулд ашиглахгүй болно.

6.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийн нууцыг задруулах, бусдад ашиглуулахаас зайлсхийн өндөр хариуцлагатай, сонор сэрэмжтэй хамгаална.

6.3 Харилцан шилжүүлэн өгсөн бөгөөд бичгээр үйлдсэн мэдээллийг байгаль орчны аудитын тайланд хавсаргана

Долоо. Бусад заалт

7.1 Гэрээнд өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2 Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монгол Улсын холбогдох шатны шүүхээр Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

Найм. Талуудын хүлээх үүрэг

8.1 Аудитын зөвлөмжөөр өгөгдсөн үүргийг захиалагч биелүүлнэ.

8.2 Захиалагч байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний тайланг зөвлөмжийн хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

8.3 Гүйцэтгэгч нь байгаль орчны аудитыг холбогдох хууль, журам, аргачлалын дагуу гүйцэтгээгүйн улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

8.4 Захиалагч нь байгаль орчны аудитыг гүйцэтгэж байх хугацаанд Гүйцэтгэгч талыг үнэн зөв мэдээллээр хангаагүй, технологийн үйл ажиллагааг санаатайгаар буруу тайлбарласан, аливаа зөрчил дутагдлыг нуун дарагдуулсан эсвэл илт худал мэдээлэл өгсний улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

8.5 Захиалагч байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй, авч хэрэгжүүлсэн ажлын тайланг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүйн улмаас үүссэн аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

Ес.Талуудын хаяг:

Захиалагч:

Хаяг: Улаанбаатар-14250,
Сүхбаатар дүүрэг 6-р хороо,
11-р хороолол, Их сургуулийн гудамж

Утас/Факс:

И-мэйл:@gmail.com

Гүйцэтгэгч:


Хаяг: Монгол улс, Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
1-р 40 мянгат, 23-р байр 20 тоот

Утас/Факс: 976-99999961

И-мэйл:

ebgconsulting99@gmail.com

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН





БАТЛАВ.



“ЭБГ КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛГ
/ Б.ТАНЧИМЭГ /

“Жи энд Юу голд” ХХК-ИЙН
ЗАХИРАЛГ
/ Г.ЦИНТӨМӨР /

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

2023 оны 06-р сарын 01 өдөр

Дугаар А/25/23

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас “ЭБГ КОНСАЛТИНГ” ХХК (цаашид Гүйцэтгэгч гэх), нөгөө талаас “Жи энд Юу голд” ХХК (цаашид Захиалагч гэх) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

1.2. Гэрээ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Иргэний Хуулийн 189.5 дахь хэсэг, БОНХС-ын 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А-126 дугаар тушаалын 4.4-ийг удирдлага болгосон ба гэрээний зорилго нь талуудын хооронд хамтран холбогдох эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий нөхцөл

2.1. Аудит хийлгэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, БОА хийлгэхээр энэхүү гэрээг байгуулж байна.

2.2. Гүйцэтгэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Баянхонгор аймагт байрлах “Ихэрийн-Ам”-ны алтны шороон ордын уурхайн үйл ажиллагаанд БОА-ыг гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулж байна.

2.3. Талууд байгаль орчинд учруулж болзошгүй аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, аудит хийлгэгчийн экологи, эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, аудит хийлгэгч талд учирч болзошгүй хохирол, эрсдэл, алдагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор БОА хийхээр харилцан тохиролцсон болно.

2.4 Байгаль орчны Аудитад дараах объектуудыг хамруулна

- Ил уурхайн карьер
- Угаах төхөөрөмж
- Туслах барилга байгууламж болон ажилчдын кемп
- Хөрсний болон шимт хөрсний овоолго
- Технологийн зам талбайнууд
- Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалалт хийсэн талбай
- Унд ахуйн болон технологийн усны эх үүсвэрүүд (худаг), ус дамжуулах шугам хоолой, Ус цэвэршүүлэгч байгууламж, усан санууд,
- Халаалтын зуух
- Цэвэрлэх байгууламж болон бохирын худагууд
- Хогийн цэг болон туслах байгууламжуудын хог хаягдлын цэг,
- Засвар механикийн цех
- Ногоон байгууламж

БОА-ыг ажлын 45 хоногт багтаан гүйцэтгэнэ.

Гурав. Гэрээт ажлын төлбөр

3.1. Ажлын нийт хөлс нь гэрээнийн Хавсралт 1 заасны дагуу : **10,000.0 (арван таван сая)** мян.төгрөг /НӨАТ-тэй үнэ/байна. Үүнд татвар, хураамж, аудиторын баг, тээврийн зардал бусад ажлын гүйцэтгэлтэй холбоотой зардлууд багтсан болно.

3.2. Гэрээний 3.1 дэх хэсэгт заасан төлбөрийн 50 % болох 5,000.0 (долоон сая таван зуун мянга) мян.төгрөгийг Гэрээ байгуулагдаж нэхэмжлэх хүлээж авсаны дараа ажлын 2 хоногийн дотор харилцагчийн дансанд буюу бэлнээр шилжүүлнэ.

3.3. Гэрээний үлдэгдэл 50% болох 5,000.0 (долоон сая таван зуун мянга) мян.төгрөгийг холбогдох ажлуудыг бүрэн гүйцэтгэж, тайлан материал, баримтуудыг Захиалагч талд хүлээлгэн өгсөнөөс хойш нэхэмжлэх хүлээж авсаны дараа ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ.

Дөрөв. Аудит хийлгэгчийн эрх, үүрэг

4.1. БОА-ын гүйцэтгэгчийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2 БОА хийхэд шаардагдах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, тодотгол, төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аудит хийлгэх хугацааны хяналт шинжилгээний хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилт, дотоод аудитын тайлан, төлбөрийн баримтууд, өмнөх аудитын тайлан, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл болон бусад холбогдох мэдээ материал зэргийг гүйцэтгэгчийн мэдэлд шилжүүлнэ.

4.3. Гэрээнд заасан хугацаанд БОА хийж дуусгахыг гүйцэтгэгч талаас шаардах эрхтэй.

4.4. Гүйцэтгэгч талын боловсруулсан БОА хийх төлөвлөгөө, хөтөлбөр болон графикийн дагуу ажил гүйцэтгэх нөхцөлөөр хангах үүрэгтэй.

4.5. Гүйцэтгэсэн ажлыг комисс гарган актаар хүлээн авч болно.

4.6. БОА-ын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.7 Зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг харьяалах орон нутгийн байгаль хамгаалах газарт зөвлөмжинд заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1. БОА хийлгэхээр аудит хийлгэгчээс ирүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, тодотгол, төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аудит хийлгэх хугацааны хяналт шинжилгээний хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилт, дотоод аудитын тайлан, төлбөрийн баримтууд, өмнөх аудитын тайлангийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.

5.2. Гэрээнд заасан хугацаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу чанарын өндөр түвшинд ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

5.3. БОА-ын ажлыг заавал биечлэн гүйцэтгэнэ.

5.4. Аудит хийлгэгч нь ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцох эрхтэй.

Зургаа. Хамтран хүлээх үүрэг

6.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

6.2. Харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.3. Гэрээг 2 хувь үйлдэж БОА гүйцэтгэгч консерциум байгууллага болон аудит хийлгэгч байгууллага тус бүр нэг хувийг эзэмших бөгөөд хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

6.4. БОА-ын тайланг 2 хувь үйлдэж аудит хийлгэгч байгууллага, гүйцэтгэгч байгууллага нь тус бүр нэг хувийг эзэмшинэ. Тэдгээр нь адил хүчинтэй байна.

АТАР ХОТ

БГ
АЛТИНГ
ХК

939 5107717

АТАР ХОТ

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээний хугацаанд БОА-ын ажил гүйцэтгэх үед давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр гэх мэт байгалийн гамшигт үзэгдэл, халдварт өвчний тархалт, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо зэрэг нийгмийн нөлөөлөл) тохиолдож гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хугацааг сунгах үндэслэл болно.

7.2. Давагдашгүй хүчин зүйл бий болсон нотолгоог тухайн харьяа газрын төрийн захиргааны байгууллагаас авч болно.

Найм. Мэдээллийн нууцыг хадгалах

8.1. Гүйцэтгэгч нь Аудит хийлгэгчээс хүлээн авсан нууцад тооцогдох мэдээллийг бусад байгууллага, хувь хүмүүст зарлан тараахгүй бөгөөд гэрээнд дурьдсан зорилгоос өөр аливаа хэлбэрээр ашиглахгүй.

8.2. Гүйцэтгэгч нь аудит хийлгэгчийн мэдээллийн нууцыг өөрийн компанийн нууцын зэрэглэлд авч үзэж бусдад задруулах, ашиглуулахаас зайлсхийж, хариуцлагатайгаар хамгаална.

Ес. Хүлээх хариуцлага

9.1. Гүйцэтгэгч нь БОА-ын тайлан, дүн мэдээний үнэн зөв байдлыг хариуцна.

9.2. Гүйцэтгэгч нь БОА-ыг холбогдох арга, аргачлалын дагуу гүйцэтгээгүйн улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

9.3. Аудит хийлгэгч нь БОА-ын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй, дүгнэлт зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг харьяа газрын байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

Арав. Бусад заалт

9.1. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцож, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, гэрээнд нэмэлтээр тусгана.

9.2. Аливаа маргааныг талууд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр эцэслэн шийдвэрлэнэ.

Арван нэг. Захиалагч талуудын хаяг

Монгол улс, Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
1-р 40 мянгат, 23-р байр 20 тоот
Утас: +976-99099961,
976-94949961


И-мэйл: ebgconsulting99@gmail.com

Улаанбаатар - 210524, Сүхбаатар
дүүрэг, 6-р хороолол, Их сургуулийн
гудамж-23, АВ төв, 9-р давхар
901 тоот
Утас/Факс: +976 80809616
70174070

И-мэйл:
Dulamsurenbatkhuyag@gmail.com

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭБГ КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН
АУДИТОР

 /Б.БАЙГАЛ/

АУДИТ ХИЙЛГЭГЧ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Жи энд Юу голд” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН
/Д.Батхуяг/